



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлзийт сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2024/18-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn
Архангай аймаг
2024 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn
Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn
Аудитор В.Цогжаргал
Цахим хаяг: Tsojargalb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	8
3.1 Албан шаардлага	8
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	8

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhantai@audit.gov.mn

2024.03.25 № 168
танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ӨЛЗИЙТ
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Г.БАТТУЛГА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Архангай аймгийн Өлзийт сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөг эс тооцвол Өлзийт сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар илэрсэн доорх алдаа зөрчил нь материаллаг боловч санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө нь өргөн тархаагүй тул Хязгаарлалттай дүгнэлт хүргүүлж байна. Үүнд:

1. Хоршоо хөгжүүлэх сангийн тайланд тусгагдсан 256,059.3 мянган төгрөгийн зээлийн авлагын үлдэгдлийг зээлдэгч бүртэй тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, зээлдэгчийн бүртгэл, мэдээлэл зөрүүтэй, санхүүгийн тайланд хүүгийн орлогыг бүртгээгүй, нягтлан бодох бүртгэлийг зохих ёсоор хөтлөөгүй байна.

Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4, 8.4, 14.4, 20.2 дахь заалтыг зөрчсөн, аудитын иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитын гол асуудал

МУЗГ-ын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын дагуу тус орлогыг тайлант оноос захиран зарцуулж, тайлагнах болсон байна.

Бусад асуудлын хэсэг

Сумын засаг дарга нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 15 үндсэн зорилтын хүрээнд 131 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 90.08 хувийн гүйцэтгэлтэй үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	630,751.7	752,813.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	311,169.8	467,018.6
33	АВЛАГА	309,535.1	256,059.3
35	БАРАА МАТЕРИАЛ	10,046.8	8,836.0
36	НӨӨЦИЙН БАРАА	0.0	20,900.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,879,676.3	2,090,040.9
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,879,676.3	2,090,040.9
39200	Биет хөрөнгө	1,867,619.3	2,078,058.9
39300	Биет бус хөрөнгө	12,057.0	11,982.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,510,428.0	2,842,854.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.0	1,859.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.0	1,859.0
41300	Өглөг	0.0	1,859.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,510,428.0	2,840,995.8
51	Засгийн газрын хувь оролцоо	2,510,428.0	2,840,995.8
51100	Засгийн газрын оруулсан капитал	433,047.4	433,047.4
51200	Хуримтлагдсан үр дүн	1,355,318.8	1,685,886.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	722,061.9	722,061.9
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,510,428.0	2,842,854.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,110,352.9	1,939,062.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	347,290.4	438,293.2
110	Орлогын албан татвар	248,640.3	284,240.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	248,634.0	284,040.4
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	6.3	200.0
113	Хөрөнгийн албан татвар	82,371.9	111,100.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	16,278.2	42,952.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	431,176.3	375,536.0
120	Нийтлэг татварын бус орлого	431,176.3	375,536.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,331,886.1	1,125,232.9
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,580,984.3	1,316,241.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,576,584.3	1,290,641.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,706,623.0	1,274,089.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	363,083.0	460,979.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,725.3	57,596.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,060,370.0	42,342.1
2104	Хангамж, бараа материалын зардал	35,877.8	41,872.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,577.3	5,046.0
2107	Томилолт, зочны зардал	3,994.0	4,190.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,539.0	516,935.9

Архангай аймгийн Өлзийт сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	146,456.6	145,127.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,869,961.2	16,552.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,400.0	25,600.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	529,368.6	622,820.8
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,934,654.6	292,253.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-4,405,286.0	330,567.8

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,781,206.8	1,684,561.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	347,290.4	438,293.2
110	Орлогын албан татвар	248,640.3	284,240.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	248,634.0	284,040.4
113	Хөрөнгийн албан татвар	82,371.9	111,100.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	16,278.2	42,952.7
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	9,592.7	25,320.8
1181	Газрын төлбөр	3,912.5	15,589.4
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	2,773.0	2,042.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	102,030.2	120,534.9
120	Нийтлэг татварын бус орлого	102,030.2	120,534.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,331,886.1	1,125,732.9
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,470,720.3	1,160,859.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,470,720.3	1,160,859.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,598,288.3	1,144,307.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	363,083.0	460,968.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,770.5	57,596.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,060,112.5	42,342.1
2104	Хангамж, бараа материалын зардал	35,877.4	40,013.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,577.3	5,046.0
2107	Томилолт, зочны зардал	3,994.0	4,190.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,539.0	519,050.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,334.6	15,100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,872,431.9	16,552.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	310,486.5	523,701.7
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	174,753.8	317,853.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	174,753.8	317,853.0
2200	Дотоод эх үүсвэрээр	174,753.8	317,853.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-174,753.8	-317,853.0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-90,000.0	-50,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	90,000.0	50,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	45,732.7	155,848.7

Архангай аймгийн Өлзийт сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	265,437.2	311,169.8
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	311,169.8	467,018.6

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,336,830.3	6,336,830.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	578,883.6	578,883.6
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,915,714.0	6,915,714.0
9	Тайлант үеийн үр дүн	-4,405,286.0	-4,405,286.0
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,510,428.0	2,510,428.0
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,510,428.0	2,510,428.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,510,428.0	2,510,428.0
19	Тайлант үеийн үр дүн	330,567.8	330,567.8
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,840,995.8	2,840,995.8

2.4 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,705,712.30	1,525,837.10	179,875.20	89.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,167,612.10	1,157,984.10	9,628.00	96.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,151,060.00	1,141,432.00	9,628.00	96.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	464,156.90	460,968.70	3,188.20	97.89
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,982.20	57,596.10	386.10	97.27
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	528,951.10	523,504.00	5,447.10	95.34
2104	Хангамж, бараа материалын зардал	39,145.20	39,047.20	98.00	98.41
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,946.00	31,946.00	0.00	98.87
2107	Томилолт, зочны зардал	4,200.00	4,190.00	10.00	99.85
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,578.60	9,080.00	498.60	97.37
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,100.00	15,100.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,552.10	16,552.10	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,552.10	16,552.10	0.00	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	458,900.20	317,853.00	141,047.20	50.65
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	79,200.00	50,000.00	29,200.00	90.86

Архангай аймгийн Өлзийт сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,705,712.30	1,590,429.90	115,282.40	85.99
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,476,547.30	1,485,613.10	-9,065.80	94.77
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	229,165.00	104,816.80	124,348.20	31.68
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	69,557.40	-69,557.40	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	134,150.20	-134,150.20	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	56	56		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2		
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	27	27		
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	27	27		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,875.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,875.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,875.1
2104	Хангамж, бараа материалын зардал	966.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,908.9
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,875.1
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,875.1

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй. Аудитаар залруулагдаагүй нийт **256,059.3** мянган төгрөгийн зөрчил¹ илэрч зөрчлийг арилгуулах 1 албан шаардлага хүргүүлээ.

3.1 Албан шаардлага

3.1.1 Хоршоо хөгжүүлэх сантай холбоотой

Илрүүлэлт: Хоршоо хөгжүүлэх сангийн тайланд тусгагдсан 256,059.3 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг зээлдэгч нэг бүртэй тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, зээлдэгчийн мэдээлэл, бүртгэл нь зөрүүтэй, тайлант оны хүүгийн орлогыг нягтлан бодох бүртгэлд тусгаж тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4.үнэн зөв байх, 8.4.Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна. Санхүүгийн тайланг цахим хэлбэрээр гаргах тохиолдолд цахим гарын үсэг хэрэглэж баталгаажуулна. 14.4.Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ, 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага, 14.4.5.бүх орлого, 20.2.Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ 20.2.3.холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах, 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах, 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, **үлдэгдлийг баталгаажуулж**, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, зээлдэгчийн мэдээллийн зөрүүг арилгах, зээлдэгч тус бүрийн эргэн төлөх төлбөрийн дүнг гаргаж тооцоо нийлэн баталгаажуулан нягтлан бодох бүртгэлд тусгах арга хэмжээ авч нотлох баримтыг дахин шалгуулах хугацаатай албан шаардлага хүргүүлээ.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/											
			Үүнээс											
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Санхүүгийн тайлан дахь авлагыг баталгаажуулаагүй	1	256,059.3	-	-	1	256,059.3					-	-	-	-
Нийт дүн	1	256,059.3	-	-	1	256,059.3								

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.